

**«ЦАСТЫН ОРОН»-Ы СОЁЛ
БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН
БАЙДЛААС**

Д. Энхтайван

БНХАУ бол олон үндэстний том орон. Түүний нутаг дэвсгэрт 50 гаруй үндэстэн оршин суудаг. Тэдний нэг нь Төв Азийн соёл иргэншилд гүнзгий ул мөрөө үлдээсэн түүх, соёлын арвин их дурсгалтай Төвд үндэстэн юм. Төвдийн ард түмэн үндэстний өвөрмөц соёл, түүхэн дадал заншлаа олон зуун жилийн турш хэвээр хадгалахыг эрмэлзсээр өнөөг хүрчээ.

Төвд бол шашин, шашин бол Төвд гэж хятадын хэвлэлд бичсэнээс үүдэн Төвдийн түүхийг эргэн үзэх юм бол буддын шашин тус орны нийгэм улс төр, соёл, ард түмний зан заншил ахуйд нэвт шингэснийг мэдэж болно. Энэ нь төвдүүдийн үндэстний онцлогийн нэгэн гол шинж мөн.

Энэтхэгээс Төвдөд дэлгэрсэн буддын үзэл нь төвдүүдийн үздэгээр янз бүрийн ухааныг хамарсан уян хатан, гүн гүнзгий сургаал учир олон зуун жилээр төвд түмний сэтгэл зүрхийг эзэмдэж, зан үйлийн нь хэм хэмжээ болсоор байгаа ажээ. Энэ нь өнөөгийн Төвдийн нийгэм улс төрийн амьдралд ч ямар нэгэн хэмжээгээр нөлөөтэй хэвээр байна гэж үзэх үндэстэй юм. Аливаа ард түмний үндэстний онцлогийг ухаарч мэдэхийн тулд тэдний оюун санааны дүр төрхийг бүхэлд нь түүнд нөлөөлж байгаа нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлох нь чухал юм. Төвдийн феодализмын үзэл суртал шарын шашин нь нарийн зохион байгуулалттай эдийн засгийн асар их хүч тэй, улс төрийн өндөр эрх мэдэлтэй, үзэл суртлын нөлөө бүхий хүчин байжээ. Тиймээс ч олон зуун жилд батжиж бэхжсэн төр, шашны ёсыг тусгаарлах хэргийг дэс дараатай, уян хатан арга хэмжээгээр явуулахыг тус орны өвөрмөц байдал шаардаж байсан. Гэтэл «соёлын хувьсгал»-ын жилүүдэд шашныг төрөөс тусгаарлах явдлыг урьдчилсан арга хэмжээ авалгүйгээр хууль гаргаж, хүчээр тунхаглаж, үндэстний зан чанар, үндэстний сэтгэлгээний онцлог, угсаатны зүйн байдаг зэрэг нарийн хандах ёстой зүйлд анхааралтай бус хандаж байснаас үүдэн гарсан ноцтой алдааг хятадын өнөөгийн удирдагчид буруушаан шүүмжилж, учирсан хор хохирлыг арилгах, үндэстэн хоорондын харилцааг сайжруулах, цөөнх үндэстний районуудын хоцрогдсон эдийн засаг, соёл боловсролыг хөгжүүлж, ард түмний нь

7. Кроль Ю. Л. Китайцы и «Варвары» в системе конфуцианских представлений о Вселенной. Народы Азии и Африки, 1978. 6. с. 45—57

8. «Мин тай зу ши лу». Цз. 119. Хун у-гийн 11 оны 6-р сарын хар хулгана өдөр.

9. «Мин тай зу ши лу». Цз. 121. Хун у-гийн 11-р оны 12 сарын шар луу өдөр.

10. «Миң тай зу ши лу», Цз. Хун у-гийн 21-р оны 8-р сарын шар луу өдөр

11. «Мин тай зу ши лу» Цз. 120. Хун у-гийн 11-р оны 10-р сарын хөхөгчин үхэр өдөр.

12. «Мэнгу зу зяньши». (Монгол үндэстний товч түүх), Хөх хот. 1985. 130-р тал.

13. «Мин тай зу ши лу». Хун у-гийн 21-р оны 10-р сарын улаан морь өдөр.

аж амьдралыг дээшлүүлэх талаар зохих арга хэмжээ авч явуулж байна.

1980 оны хавар ХКН-ын Нарийн бичгийн дарга нарын газраас «Төвдийн асуудлаархи ажил хэргийн хуралдаан»-ыг анх удаа зохион байгуулан явуулж «Шинэ Төвдийг байгуулах» тухай 6 зүйлт зорилтыг дэвшүүлсэн нь ач холбогдолтой зүйл болсон. 1985 оны 3-р сард уг асуудлаархи 2 дахь удаагийн зөвлөлгөөнийг Бээжинд хийж «Баруун хойт хятадын уудам зэлүүд нутгийн байгалийн баялагийг нээн ашиглах улмаар XXI зуунд хятадын эдийн засгийн гол түшиц газар болгон хувиргах стратегийн зорилтыг дэвшүүлсэн нь¹ цөөнх үндэстэн бөөнөөр оршин суудаг хил хязгаар орныг нээн эзэмших бодлогыг явуулахын чацуу хятадын удирдагчид орон нутаг дахь үндэстний харилцааны асуудлыг зөв зохистойгоор яаралтай шийдвэрлэх чиглэлийг баримталж байгааг гэрчилж байна.

Төвдийн өөртөө засах орны Намын хорооны III бүгд хурлаас (1984 оны 12-р сарын) Төвдийг Хятадын бүх муж, районтой харилцаатай байлгах гадаадад «Нээлттэй» болгох шийдвэрийг албан ёсоор нийтэд зарласан нь олон жилийн турш гадаад ертөнцөөс тусгаарлагдмал байсан төвдийн хувьд онц чухал ач холбогдолтой зүйл болсон юм. Сүүлийн жилүүдээс «Нээлттэй» бодлогын хүрээнд жуулчлал хөгжсөнөөр Төвдийн эртний түүх соёлын бодит гэрч болсон сүм хийд нь гадны жуулчдын сонирхолыг татсан үзмэр болж, валют олох их сурвалжийн нэг болж байна. 1980 оноос хойш 36 сая гаруй юаний хөрөнгө тусгайлан гарган эвдэж сүйдсэн сүм хийдийг сэргээн засварласан байна.²

«Шинэ Төвдийг» байгуулахад тус районы шинжлэх ухаан, соёл боловсролыг эрчимтэй хөгжүүлж, төвд үндэстний боловсон хүчнийг олноор бэлтгэх нь нэгэн гол асуудал болох тул үүнд нэлээд анхаарал хандуулах хэрэгтэй хэмээн үзэж зохих арга хэмжээ авч байна. Одоогийн байдлаар Төвдийн 1 сая 770 мянган малчид, тариачдын³ 80% нь бичиг үсэг огт мэдэхгүй байгаа нь⁴ хөдөөгийн хүн амын соёл боловсролын түвшин тун доогуур, төвөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ тэр бүр оновчтой биш, үр дүн багатай, нөгөөтэйгүүр хязгаар нутагт хэрэгжихгүй байгаатай холбоотой. Энэ байдлаа ч Дэн Сяопин хүлээн зөвшөөрч «10 жилийн шинэтгэлийн явцад гарсан хамгийн том талдаа бол боловсролыг хөгжүүлээгүй явдал мөн. Үндэсний нийт бүтээгдэхүүний дотор боловсролын зардал 1988 онд 2,98% байсан. Энэ нь хөгжиж буй орныхоос 4%, Энэтхэгээс 3,7% бага байгаа юм»⁵ гэжээ. ХКН-ын XIII их хурлаас: Өнөө үед хятадын бүх хүн амын 1/4 хувь нь бичиг үсэг огт мэдэхгүй, эсвэл хагас дутуу мэдэж байгааг тэмдэглээд хот хөдөөгийн хүн амыг бүрэн бус дунд, томоохон хотуу дын хүн амыг дунд боловсролтой болгох зорилт дэвшүүлжээ.⁶

ТӨЗО-ы сургалт хүмүүжлийн ажилд сүүлийн жилүүдэд багагүй анхаарч байгаагийн учир шалтгаан чухам үүнд захирагдаж байгаа билээ. Хятадын хэвлэлийн мэдээнээс үзвэл төвд хэл сургах тухай асуудал тус районд яригдах боллоо. Урьд өмнө үндэсний хэлийг ингэж онцгойлон үздэггүй байсан юм.

Төвдийн нэр хүндтэй сэхээтнүүдийн нэгэн болох Дунгарлуvsанпэрэнлэй үндэсний сургалт хүмүүжлийн ажилд оршиж буй багш нарын мэдлэг сул дорой, хичээлийн байр хүрэлцээгүй, сургалтын материаллаг бааз хангалтгүй байгаа дутагдлыг шүүмжлээд багш сурган хүмүүжүүлэгчдэд системтэй мэдлэг олгох, төвд хэлээ төгс эзэмших, улсаас гаргаж буй тусламжийн мөнгийг үр ашигтай нарийн тооцоотой зарцуулах, уламжлалт сургалтыг орчин үеийнхтэй хослуулах хэ-

рэгтэй байгаа тухай «Төвдийн соёлд өчүүхэн судалгаа хийсэн нь» хэмээх номдоо бичсэнээс үзвэл төвдийн сэхээтнүүд соёл боловсролоо хөгжүүлэх, ирээдүй хойч үедээ санаа тавьж байдгийн нэгэн гэрч мөн. Ийм хүмүүсийн нэг бол ТӨЗО-ны Засгийн газрын дарга Дорж Цэдэн зүй ёсоор орно. Тэрээр энэ албан тушаалд орсноосоо хойш Төвдийн шинжлэх ухаан, соёл, боловсролыг хөгжүүлэх, үндэсний боловсон хүчин бэлтгэн гаргахад идэвхтэй үүрэг гүйцэтгэж байгаа юм.

Одоо Төвдөд их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургууль 18, дунд сургууль 67, бага сургууль 2453 байна.⁷ 1985 онд Төвдийн анхны Их сургууль Лхас хотноо нээгдсэн нь ТӨЗО-ны соёл боловсролын амьдралд гарсан томоохон үйл явдал мөн.

Тус өөртөө засах орны эдийн засгийн хоцрогдсон байдлыг нь харгалзан үзэж Хятадын засгийн газраас зарим нэгэн хөнгөлөлт үзүүлж байгаа нь боловсролын салбарт ч мөн харагдаж байна. Жишээ нь: Хятадын бусад газруудын бага сургуульд суралцахад жилдээ 42 юань, дунд сургуульд 50 орчим юань төлдөг бол төвдийн бага, дунд сургуульд үнэ төлбөргүй суралцах, харин их, дээд сургуульд төвийн муж районхоос 2 дахин бага хөлс төлж суралцах болжээ.⁸ Боловсролын салбарт бусад муж, районууд хүн, хүчний болон эд материалын тусламж үзүүлж байгаагийн нэг баримт бол 17 муж, хотын сургуулиудад төвд анги нээж түүнд 4000 орчим төвд хүүхдүүд сурч байгаа болно.⁹

Төвдийн Шинжлэх Ухааны Академийг байгуулах бэлтгэл ажил 1978 онд эхэлж 1985 онд албан ёсоор байгуулснаа зарласан. Академи нь үндэстний судлалын хүрээлэн, Шашны судлалын хүрээлэн, Төвд хэлний хүрээлэн зэрэг 6 хүрээлэн, төвд судлалын редакци, мэдээллийн тасагтай.¹⁰

ТӨЗО-д зохиолч, яруу найрагч, дуучин, бүжигчин, хөгжимчин зэрэг соёл урлагийн ажилтан 3,900-аад байна.¹¹ Төвдийн дуу бүжгийн чуулга 1987 онд АНУ, Японд очиж тоглосон ба мөн оны зун Танган¹² зургийн үзэсгэлэн Францад нээгдсэн нь үзэгчдийн сонирхлыг ихэд татжээ.

Нийгмийн ухааны салбарт тус орны төвд ард түмний эрт эдүгээгийн түүх, хэлбичиг, уран зохиолыг судлах ажлыг сэргээгээд байна. Хэрвээ төвдийн соёлын уламжлагдсан гайхамшигт зүйлсийг тууштайгаар хамгаалахгүй бол төвдийн соёлын байгуулалтын үндэс үгүй болж, өөрийн өвөрмөц шинжийг алдаж болох аюултайг БХАТИХ-ын Байнгын хорооны орлогч дарга агсан Банчин Эрдэнэ нэг бус удаа сануулж байсан нь тохиолдлын хэрэг биш юм. Энэ нь арван жилийн самуурлын хор уршиг одоо ч бүрмөсөн арилаагүй байгаатай холбоотой.

Төвдийн ард түмний өвөг дээдэс төвд, хятад, энэтхэг ба бусад олон орны түүх, ба газар зүй, гүн ухаан, хүн эмнэлгийн талаар олон тооны жинхэнэ эх зохиолуудыг туурвисан билээ. 300 гаруй боть судар Ганжуур, Данжуур нь зөвхөн шашны сэдэв ороод зогсоогүй мөн санскрит хэлнээс орчуулсан өдий төдий уран зохиол, гүн ухаан, тоо, хэл зэргийн олон зүйл орсон. Үүний ачаар ч төвдүүд энэтхэгийн соёлын шилдэг бүтээлүүдтэй танилцжээ. Дэлхий дахинд алдартай «Рамаяана», «Панчатантра» зэрэг энэтхэгийн утга зохиолын дээжис болсон зохиолууд төвдөд дэлгэрчээ.

Хүн төрөлхтний бахархал болсон шилдэг бүхэн үндэсний хөрсөн дээр төдийгүй нийт хүн төрөлхтний ололтыг бүтээлчээр боловсруулах замаар буй болдог. Ийнхүү үндэсний соёлын харилцан нөлөөлөл, харилцан холбоо нь дэлхийн соёлын хөгжих чухал нөхцөл болж өгдөг. Төвд үндэстний соёлын өвөрмөц онцлог мэдээжээр олон зуун жилийн

турш бүрэлдэж тогтсон нь үнэн боловч өнөөдөр түүнд шинэ агуулга оруулдаг шинэ нийгмийн үйл явцын хамт хөгжин баяжиж байна.

Эцэст нь дүгнэж хэлэхэд ХКН-аас ТӨЗО-ы хувьд авч явуулж буй арга хэмжээ нь феодалын хамжлагат нийгмийн хоцрогдлыг арилган нийгэм-эдийн засгийн дэвшилтэд өөрчлөлт хийж, энэ орны ард түмнийг хоцрогдлоос нь бүрэн чөлөөлөх ажил хийгдэж байгааг Төвдийн өнөөгийн бодит байдал харуулж байна.

ТӨВДИЙН СҮМ ХИЙД

Л. Лхамдулам

Цастын орон Төвд. Энэ нэрийг сонсоход юуны түрүүн буддын шашны нөлөө гүн шингэсэн эртний орон, олон жилийн түүхт сүм хийдүүдийн шижиртэн гялалзах алтан ганжир нарны хурц гэрэлтэй хослон нүд гялбуулж, үнэн сүсэгт олон түмний хөл үл тасрах гудмуудад хааяагүй тааралдах лам хуврагууд нүднээ үзэгдэх шиг.

Европын нэрт жуулч-эрдэмтдийн бүтээлүүдэд Төвдийг «бурхан шашин шид тарнийн орон» хэмээн онцлон олонтаа тэмдэглэсэн байдаг нь энэхүү орны талаар мэдэхийг хүссэн хэн бүхний сониуч занг өөрийн эрхгүй хөндөх ажээ. Төвдийн нийслэл Лхасын нэрийн гарал үүслийн учрыг хөөвөл дэлхийн хамгийн өндөрлөгт орших энэхүү өвөрмөц орны талаар олонхи жуулч-эрдэмтдийн хийсэн дээрх дүгнэлтийг давхар нотолно.

Төвдөд буддын шашныг дэлгэрүүлэхэд багагүй үүрэг гүйцэтгэсэн хүн бол VII зууны эхэнд Төвдийн олон бутархай овог аймгуудыг нэгтгэн Туфаны төр улсыг байгуулсан Соронзонгомбо хаан юм. Тэрээр төр барих хугацаандаа Балбын Амчобарман хаан, Хятадын Тайзун хаантай ургийн холбоо тогтоож, Чизун, Вэн Чэн нэртэй хоёр гүнжийг хатнаа болгосон ба тэд Төвдөд ирэхдээ Шигжамүни бурхны хөрөг авчирч анхны бурхан шүтээний зууг Лхаст бариулсан түүхтэй.

«Нарны хот» хэмээгддэг Лхасын төвд орших Их зуу сүмийг цагаан ямаагаар шороо зөөлгөн орчны намаг балчгийг арилган бариулсан тухай домог яриа өнөөг хүртэл төвд үндэстэн ард түмний дунд ам дамжин яригдсаар иржээ. Төвдөөр ямааг «ра», шороог «са» хэмээн дууддаг тул тэр газрыг эхний үед «раса» хэмээн нэрлэж байлаа. Хожмоо Төвдөд буддын шашин дэлгэрч, сүм хийд олноор баригдан Төвд

1. «Миньцзу туаньцзе» 1985. № 11
2. «Сизан байти вэньда» Бээжин, 1988.
3. «Байкэ няньцзянь», 1985.
4. «Ши жа» (сэтгүүл, Драмсала. 1986. №3
5. «Жэньминь жибао» 1989. III. 24
6. «Жэньминь жибао» 1987. XI. 4
7. «Гуанминь жибао» 1989. III. 30
8. «Правда» 1986. VIII. 19
9. «Миньцзу туаньцзе» 1988. № 6
10. «Чайна квартири» 1988, 9-р сарын дугаар
11. «Төвдүүд төвдийн тухай» 1988
12. Танган гэдэг нь төвдийн дүрслэх урлагийн нэг өвөрмөц төрөл бөгөөд МЭ VII зууны эхээр үүсэн хөгжжээ.